

ХУУЧИН БАРГЫН ҮҮСЭЛ, ХУВЬСАЛ

А.Янагисава

Товч утга: Энэ өгүүлэлд, манж хэлээрх архивийн баримтыг гол сурвалж болгон ашиглаж, 1688 оны Галданы довтолгооны улмаас Хармөрөнд зугтан орсон Халхын Сэцэн хан аймгийн ноёдын харьяат баргуудыг 1690 онд Хармөрөний жанжсин нар хураан авч Мүгдэн, Жилин болоод Цахарт хуваан суулгасан, мөн 1694 онд нэг хэсэг баргуудыг хурааж Чичихарт суулгасан, тэрхүү Чичихарт суусан барга нарыг хожим 1734 онд Хөлөнбуйрт эргүүлэн нүүлгэн суулгасан нь “Хуучин барга” хэмээгдэх болсон зэрэг түүхэн үйл явдлыг тодорхой болгожээ. Түүний сацуу Халхын ноёдын харьяанд хэвээр үлдсэн баргуудыг мөн 1734 онд Хөлөнбуйрт нүүлгэсэн нь “Шинэ барга” болох бөгөөд Хуучин ба Шинэ баргын хооронд тодорхой зааг ялгаа байгаагүй атал өнөөгийн тэднийн соёлын ялгааг, 1) хуучин баргын өвөг дээдэс Их Хянганы нуруунаас зүүн тийш Нон мөрөний сав газраар солон, дагуур нартай нутагласан 40 жил, 2) үүний нөгөө талд хуучин баргууд эргэн Хөлөнбуйрын тал нутагт нүүснээр тэднийг тариачин болох, монгол бус угсаатанд уусах явдлаас зайлуулсан, 3) Хөлөнбуйрт нүүсний дараах Чингийн захиргааны тогтолцоо буюу Шинэ, Хуучин баргын засаг захиргааны нэгдмэл бус байдалтай холбон үзвэл зохино хэмээх санал дэвшүүлжээ.

Түлхүүр үг: Барга, Халхын ноёд, Галданы довтолгоон, Хармөрөн, Хармөрөний жанжсины яамны данс, Шинэ, Хуучин баргын ялгаа

1. Оршил

Миний бие эдүгээ хүртэл Чингийн үеийн Хармөрөн (одоогийн Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөлөнбуйр аймаг багтана) дэх угсаатны бүлгүүд нь Чин улсын найман хошууны тогтолцоонд багтаж орсон үйл явцыг дараах мэт хоёр үндсэн асуудлын үүднээс судалж ирэв. Нэгдүгээрт, Чингийн үе дэх найман хошууны тогтолцооны хувьсал хөгжлийн явцад тэрхүү хил хязгаарын угсаатнууд багтах болсоныг хэрхэн үзэж ойлгох, хоёрдугаарт, найман хошууны тогтолцоог суурь болгосон Чингийн төрийн засаглалын хөгжил нь түүний захиргаан дахь угсаатны бүлгийн нийгэм, соёл улмаар нэгэн угсаатны хувь дахь “нэгдэл”-д ямар өөрчлөлт үзүүлсэн тухай болно. Хоёрдахь асуудлын тухайд, миний бие нэгэнт Найралт төвийн (хойшид НТ хэмээн товчлоно. Орч) 12(1734) онд Хөлөнбуйрт нүүн ирж, найман хошуунд орсон Шинэ барга (sin-e barγu, 新巴爾虎)-ын тухай өгүүлэл нийтлүүлсэнээс¹ гадна, саяхан Хармөрөний угсаатны бүлгүүдийг

¹ Янагисава Акира “Шинэ барга найман хошуу байгуулагдсан тухай: Чин улсын үндэстэний бодлого

ерөнхийд нь авч үзэж, саналаа илэрхийлсэн² ба чингэхэд баттай дүгнэлтэнд хүрэхүйц хангалттай сурвалж байхгүй, мөн тухайлсан бүлгийн талаарх судалгааг улам бүр гүнзгийрүүлэх шаардлагатайг гүнээ ухамсарлав. Үүнд, Шинэ баргатай нэгэн гарал бүхий Хуучин барга (qayusin bargu, 陳巴爾虎)-ын тухай тус өгүүлэлд авч үзье.

Хөлөнбуйр аймгийн Хуучин барга хошуунд суух Хуучин барга бол монгол угсаатан дотор өвөрмөц онцлог бүхий бүлэг билээ. Тухайлбал, Дундад Иргэн улсын 12(1923) оны “Хөлөнбуйрын тэмдэглэл 呼倫貝爾志略”-д тэднийг зэрэгцэн нутаглах шинэ баргаас ямар ялгаатай болохыг дараах мэт тэмдэглэсэн буй.

“Хуучин барга, ... энэ бүлэг хүний байдал төлөв Солонтой төстэй авч хэл нь бага зэрэг өөр. Ламыг үл хүндлэх заншил бүхий. ... Шинэ барга, ... тэдний хэл нь хуучин баргатай нэвтрэх ба барга хэмээх нэртэй тул шинээр хошуунд оруулаад Шинэ барга хэмээсэн. ... Ламыг хүндэлж, амь насаа бурханд даатгах заншил бүхий нь хуучин баргатай гал ус мэт. “
陳巴爾虎、…… 此族人性情与索倫相近、而言語稍異。俗不敬喇嘛。……新巴爾虎、…因其言語与陳巴爾虎相通、故名巴爾虎、新編入旗、故曰新巴爾虎。……俗敬喇嘛、託命於仏、与陳巴爾虎相水火云。

Хуучин баргуудын дунд бурханы шашин дэлгэрээгүй байсныг “Манжго”-гийн үеийн хүн амын тооллого дахь нийт хүн амд эзлэх ламын хувь маш бага байснаас тодорхой харж болно³. Мөн хуучин баргын хэлний тухайд, өнөөгийн Хятадын шинжлэх ухааны ертөнцөд, барга-буриад аялгууны дотроо ч тодорхой хэмжээний өвөрмөц онцлогтой гэдгийг хүлээн зөвшөөрдөг ажээ⁴.

Хуучин барга нь НТ10(1732) онд Их Хянганы нурууны зүүн биеийн Бутха (布特哈)-гийн газраас Солон(索倫, өнөөгийн эвенк үндэстэн), Дагуур(達斡爾族), Орчоон(鄂倫春族) нарын хамт нүүн ирсэн 275 эр, тэдний гэр бүлээс шууд гаралтайд эргэлзэх хэрэг үгүй⁵. Түүнчлэн тэрхүү 275 эр нь Энх-Амгалангийн 30-д

ба найман хошууны тогтолцооны тухай судалгаа 柳澤明「新バルガ八旗の設立について—清朝の民族政策と八旗制をめぐる一考察—」” Шигаку зашши, 102-3, 1993 оны 3 сар, pp. 47-79.

² Янагисава Акира “Чингийн үеийн Хармөрөн дэх найман хошууны тогтолцооны хөгжил ба үндэстэний дахин бүрдэлт 柳澤明「清代黒龍江における八旗制の展開と民族再編」” Рэкишигаку кэнкюү 698, 1997 оны 6 сар, pp.10-21.

³ 1933 онд (Дундад Иргэн улсын 22 он) хэвлэгдсэн “Хармөрөний ойллогын ноорог 黒龍江志稿”, дэвтэр 11, Аж ахуй, улс төрийн тэмдэглэлийн овгийн хэсэгт мөн адил дурдсан буй.

⁴ Хаттори Широ “Хөлөнбуйрын монгол хэл 服部四郎「ホロンバイルの蒙古語」” Моокогаку 1, 1937 оны 4 сар, pp.97-111-д эш татсан 1934 оны Хянганы хойт мужид явуулсан судалгаанаас үзвэл, Шинэ баргын баруун зүүн хошууны (Шинэ баргын зүүн, баруун гар) нийт хүн ам 16036, үүний дотор 3035 лам байсан бол Хуучин барга хошууны нийт хүн ам 5314, үүний дотор дөнгөж 50 лам байжээ.

⁵ Жишээлбэл, Чингэлтэй “Хятад дахь монгол хэлний нутгийн аялгууг хуваах нь” (дээд), (清格爾泰「中国蒙古語方言の劃分」 Минзүянвэн, 1979-1, pp.13-20)-г үзмү. Гэхдээ нутгийн аялгууг хэрхэн хуваах, хуучин барга болон буриад-шинэ баргын хэл аялгууны холбооны тухайд олон санал буй. Харин өнөөгийн хуучин баргын соёл, зан заншилын онцлогийн тухайд, хээрийн судалгаа

онд Их Хянганы нурууны баруун талаас Бутхад орж ирсэнийг Хармөрөн мужийн жанжнаас хураан цуглуулсан хүмүүсийн үр удам гэдэг нь их төлөв тодорхой болжээ⁶. Хэдий тийм авч хуучин баргын соёлын онцлогийн эх үүсэл болоод Шинэ баргатай ямар харьцаатай болохыг тодорхойлохын тулд тэднийг Хармөрөнд хураан цуглуулах үеийн үйл явц, хожим Хөлөнбуйрт нүүх хүртэлх үеийг судалж үзэх зайлшгүй шаардлага тулгарч байна. Үүнд, ойрмогхон микрофильм хэлбэрээр ашиглаж болох боломжтой болсон “Хармөрөний жанжны яамны данс”⁷-д хуучин баргын тухай арвин мэдээлэл буй нь ихэд завшаантай. Энэхүү данс нь асар их бичиг баримтаас бүрдэх тул даруй бүгдийг гүйцэж үзэх боломжгүйд орхигдсон зүйл бага бус болов уу хэмээн санах хэдий ч уг өгүүлэлд үүнийг гол сурвалж болгон ашиглаж, баргууд Энх-Амгалангийн (хойшид ЭА хэмээн товчлоно. Орч) 30-д оны орчим Чин улсын захиргаан дор орж, түүний дараа элдэв хувьсал өөрчлөлтийг туулан өнөөгийн хуучин баргуудтай холбогдох бүлэг хэрхэн бүрэлдсэн явцыг мөшгөн үзье.

Тус өгүүлэлд нийтэд түгээгүй оноосон нэрийн манж, монгол бичгийн галигийг хадсан ба монгол бичгийн галигийн ё, ж –г с, j-р тэмдэглэв.

2. Хармөрөний жанжин баргуудыг хураасан нь

2.1 Анхны удаагийн хураалт ба нүүлгэн суулгасан тухай

Барга(巴爾虎) хэмээх нэр Энх-Амгалангийн 30-д оны үеэс Халхын Сэцэн хан аймгийн “харьяат” хэмээгдэн “Шэнзү хааны магад хууль” зэрэг Чин улсын сурвалжид гардаг. Тэдний нутаг болбаас, зүүн тийш Их Хянганы нуруу, умард тийш Оросын нөлөөний бүстэй зах нийлэх Онон, Шилка голын сав, өмнөд тийш Өвөрмонголын үзэмчинтэй зах нийлж байсан гэдэг⁸. Баргууд Их Хянганы нурууг давж Хармөрөний зүг нүүсэн нь ЭА 27 (1688) онд Зүүнгарын Галдан Халхад довтолсонтой холбогдоно. Тэрхүү довтолгооны улмаас халхууд сарнин тархаж, ихэнх нь Өвөрмонголын нутагт зугтан орж, нэг хэсэг нь Оросод дагав⁹. Тэгээд

хийгээгүй учир хангалттай баримт эс байх авч, 1994 онд очих үеэр ажигласан зүйлээс жишээ дурдвал, Хуучин баргад зун цагт гэрийн ханыг эсгий бус хулсаар бүрэх ба ийм гэрийг “хулсан гэр” гэдэг. Энэ мэт хулсан гэр сууц Эвенк үндэстэний өөртөө засах хошууны эвенкүүдийн дунд дэлгэрсэн бол харин шинэ баргад огт байдаггүй аж.

⁶ Янагисава Акира “Хөлөнбуйрт найман хошуу байгуулагдсан нь 柳沢明「關於呼倫貝爾八旗的設立」”, Ван Жунхань багшийн 80 насны ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, Ляонин их сургуулийн хэвлэлийн газар, 1993 оны 6 сар, pp.575-593. Бас Хөлөнбуйрын найман хошуу байгуулагдсан тухай тусгайлан авч үзсэн Мэргэнди, Бинба “Анх Солони зарим цэргийг Хөлөнбуйрт суулгасан түүхэн мөр 莫日根迪, 賓巴「原索倫部部分兵丁駐防呼倫貝爾史迹」” (Өвөрмонголын нийгмийн шинжлэх ухаан, 1988-4, pp.59-64) хэмээх судалгаа буй.

⁷ Tübsinnim-a nayirayulun jokiyaba, Baryucud un teüken irelte. Öbür mongγul un soyul un keblel ün qoriy-a, 1985, pp.72-89.

⁸ Энд ашигласан гол сурвалж бол Токиогийн Гадаад хэлний дээд сургуулийн харьяа Ази, Африкийн хэл соёл судлалын хүрээлэнд хадгалж буй микрофильм бөгөөд уг сурвалжийг үзэхэд тусалсан Наками Тацүо багш хийгээд тус хүрээлэнгийн ажилтнуудад талархал илэрхийлье. Дашрамд дурдахад, “Хармөрөний жанжны яамны данс”-ны тухай Ё.Күсүноки танилцуулсан буй. Күсүноки Ёшимичи танилцуулсан “Хармөрөний жанжны яамны данснаас Энх-Амгалангийн 23 оны Орос-Чингийн харилцааг харахуй” 楠木賢道「黒龍江將軍衙門档案からみた康熙二三年の露清関係」“Рэкиши жинрүй 24, 1996 оны 3 сар, pp.29-82.

⁹ Буяндэлгэр гуайн мэдээлсэнээр, бүр Эеэр засагчийн үеийн дансанд Сэцэн хан аймгийн харьяат баргын тухай тэмдэглэл байдаг аж. Түүнчлэн барга буюу түүнтэй төстэй нэрийн тухайд,

Галдан нэгэн удаа баруун хойш эгэсний дараа дахин зүүн зүгт довтолж, Их Хянганы нуруунд тулсан ЭА 29 (1690) онд олон “халх-барга нар” Их Хянганы нурууг давж, Хармөрөнд захирагдах Бутхад орж ирэв. Тэд уугуул нутгийн солон, дагуурын тариан талбайг гишгэчин, дээрэм тонуул үйлдэж буйг Солоны бүгдийн дарга Мабудай(mabudai,馬補代) нар Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны (хойшид ГМТЗЯЯ хэмээн товчилно.Орч)-нд мэдүүлж, улмаар тус яамнаас хаанд айлтгаж зөвшөөрөл авсны үндсэн дээр тэднийг харуулын гадагш хөөн гаргах, эсэргүүцэх аваас дайлахыг Хармөрөний жанжин Сабсу(sabsu,薩布素)-д тушаав¹⁰. Үүний дагуу жанжин Сабсу мөн оны 9 сарын 15-нд манж, солон, дагуур цэргийг аван Мэргэн(mergen,墨爾根) хотоос гарч, зам зуур Мабудай нартай нийлж баргуудыг цохин хөөв. Тэрхүү үйл явдлын дараалал дараах мэт. Эхлээд Сабсу нар “Ахай дайчин(ahai daicing)-гийн харьяат togonkon, ulanggot овог”-ийнхоньг хөөн гаргах гэхэд энэ хоёр овгийнхон болоод хожим орж ирсэн “ongkot овог”-ийн нэг бүлэг хүн дээрэм тонуул үйлдээгүй хэмээн Мабудай гэрчилсэн тул түр тэднийг хэвээр үлдээж, үнэхээр дээрэм үйлдсэн гэх Эрх цогт тайжийн харьяат cibcinut овгийн (нийт 1000 гаруй эр) араас мордов. Гэвч саяхан хүртэл Чичихар (齊齊哈爾) орчим байсан гэх Эрх цогт тайжийн харьяат нар Чингийн цэрэг хөдөлсөнийг тэр даруй мэдэж, Их Хянганы нурууг даван зугтаасан байв. Үүнд, Сабсу цэргийг татаж, түрүүн түр орхисон “Халхын Ахай дайчингийн харьяат баргын тогонхон (togonkon) овгийн дарга Баялай (bayalai), Дорж (dorji), улангот (ulanggot) овгийн зайсан Гэндэн (gendun), шүүлэнгэ Гүрэм (gureme), Далай жоно тайж (dalai jono taiji)-ийн харьяат онход (ongkot) овгийн Бэжэй (bejei), Амух (amuho), Дархан хунтайжийн харьяат одор (odor) овгийн Харалдай (karaldai), Далай хунтайжийн харьяат чимчигэр(cimciger) овгийн Дашихай(dasikai) нарын” бүгд 1200 гаруй эрийг харуулаас гадагш гарахыг дахин сануулсан авч, тэдний хүслээр хөөхийг больж, Чичихарын ойрхон Нон мөрний зүүн эргийн Хуюур(huuyur,呼雨爾) голоор суулгав. Гэтэл удалгүй 10 сарын 13-ны өдөр, Ахай дайчин элч илгээж, өөрийгөө Жичин(jicin) голын эхэнд ирсэн буй тул харьяат тогонхон, улангот овгийн хүмүүсийг өөрт нь нийлүүлж өгөхийг хүссэн учир дээрх хоёр овгийн 500 гаруй эрийг түүнд хүргүүлж, бусад гурван овгийн 700 гаруй эр үлдэх болов¹¹. Гэвч хожмын үйл явдлаас үзэхүл, дээрх 500 эр ч мөн адил Хармөрөнөөс гарч явалгүй тэр хавьд үлдсэн мэт.

Энэ мэт Хармөрөний жанжны баргыг хураасан үйл явдал нэлээд төвөгтэй байсан ба үүнээс гадна данс хараанаас дараах зүйл ажиглагдсаныг анхаарваас зохино. Нэгдүгээрт, тухайн үеийн барга нар овгоор бүлэглэсэн (нэг бүлэг

Монголын эзэнт улсын үеийн сурвалжид гарах хэдий ч Чингийн үеийн баргатай хэрхэн холбогдох нь тодорхойгүй. Энэ тухай миний “Шинэ баргын найман хошуу байгуулагдсан тухай”(Зүүлт 1) өгүүлэлийг үзнэ үү.

¹⁰ Халхын ноёд болоод баргуудын нүүдэл, хэрхэн салсан тухайд, дээр дурдсан “Шинэ баргын найман хошуу байгуулагдсан тухай”-гаас гадна Янагисава Акира “Галдан Халхад довтолсоны(1688) дараах Халхын ноёд ба Орос 柳沢明「ガルダンのハルハ侵攻(一六八八)後のハルハ諸侯とロシア」” Канда Нобуо багшийн жаран насны ойд зориулсан эрдэм шинжилгээний өгүүлэлийн эмхэтгэл: Чингийн төр ба Зүүн ази, Ямакава хэвлэлийн газар, 1992, pp.179-196-г үзнэ үү.

¹¹ “Хармөрөний жанжны яамны данс” 8-1690 (1690 оны 8-р данс), т.307-322, ЭА 29 оны 8 сарын 21-ний өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг, мөн т.323-335, мөн оны 9 сарын 3-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг.

зөвхөн нэг овгоос бүрдэж байсан хэмээн баталж эс чадах нь мэдээж хэрэг авч), хоёрдугаарт, баргын аль бүлэг халхын аль ноёны харьяат хэмээх эзэн харьяатын харьцаа тодорхой байжээ.

Чичихар хавиар үлдсэн хүмүүсийн тухайд, Сабсу нар тэдэнд нөөцийн будаанаас яаравчлан тараан өгч, амь тэжээх арга хэмжээ авч байсан боловч бүлэг бүлгээр хүмүүс нэмж ирсээр дараа жил буюу ЭА 30(1691) оны цагаан сард Сабсу “хоёр мянга орчим эр”¹², улмаар илүү 7 сард зэргэлдээх Дөрвөд, Жалайд хошууны нутагт буй хүмүүсийг оруулаад “гурван мянга гаруй өрхийн түм гаруй ам” хэмээн мэдүүлж байв¹³. Энэ хооронд эцсийн байдлаар тэднийг хэрхэн шийтгэх тухай хэлэлцсээр байв. Тухайлбал, мөн оны 5 сард ГМТЗЯЯ-наас Сабсу нарын саналд үндэслэн, Далай жононгийн харьяат асан ongkot овгийнхон болоод хэдийн нас барсан Хонгор дайчингийн хуучин харьяат нарыг энэ хэвээр Хармөрөнд захируулъя хэмээн айлтгасныг зөвшөөрчээ¹⁴. Үүний дагуу Сабсу 6 сарын 8-нд ongkot-ын 900 эр болон Хонгор дайчингийн хуучин харьяат 2100 эрээр бүгд 20 сум зохиож, Хуюур голоор суулгая хэмээн айлтгав¹⁵. Гэтэл тэдний байдалтай биеэр танилцсан Сабсу аж байдал нь санаснаас муу байсанд өмнөх саналаа татаж, тэднийг хагасыг Хуюур голд нутаглуулах, үлдсэн хагасыг Хорчины 10 хошууны нутагт түр суулгая хэмээх саналыг илүү 7 сарын 21-ны өдөр дахин дээш мэдүүлэв¹⁶. Чингээд ЭА 31(1732) оны 3 сарын 14-ны өдөр, зөвлөлийн бэйл, сайд

¹² “Хармөрөний жанжны яамны данс” 9-1690, т.265-311, ЭА 29 оны 9 сарын 16-ны өдрийн Хармөрөний жанжин нараас ГМТЗЯЯ-нд явуулсан бичиг. Уг дансны огноо нь 9 сарын 16 боловч агуулгаас үзвэл 10 сарын 16-ныг андуурсан мэт. Энд нэр гарах халхын ноёдыг нэг бүрчлэн тодорхойлоход хэцүү авч Ахай дайчин, Далай жоно тайж хоёрын тухайд Зүүлт 15-ыг үзнэ үү.

¹³ “Хармөрөний жанжны яамны данс” 10-1691, тал 86-90, ЭА 30 оны 3 сарын 25-ны өдрийн Хармөрөний жанжин Сабсугийн айлтгал, мөн 12-1691, т.3-9, ЭА 30 оны 5 сарын 26-ны өдрийн айлтгал.

¹⁴ “Хармөрөний жанжны яамны данс” 12-1691, т.240-249, ЭА 30 оны илүү 7 сарын 21-ний өдрийн Хармөрөний жанжин Сабсугийн айлтгал.

¹⁵ “Хармөрөний жанжны яамны данс” 11-1691, т.13-15, ЭА 30 оны 5 сарын 13-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг. Уг дансанд ongkot овгийн талаар, “утгаа халхын Далай жонон (dalai jinong)-гийн харьяат бөгөөд Оросод дагаж, дотоод сайд Сонгот (songgotu) нар Нэрчүү (nibcoo)-д хил тогтоохоор одох үеэр ongkot нар “эзнийг(хааныг) дагамуй” хэмээж Оросоос урваж ирсэн болно” гэж буй. Далай жонон гэгч бол дээр эш татсан ЭА 29 оны 9 сарын 16-ны өдрийн Хармөрөний жанжин нараас ГМТЗЯЯ-нд явуулсан бичиг (Зүүлт 12)-т нэр гарах dalai jono taiji буюу Сэцэн хан агсан Шолойн хүү Ананд бэйс болно (“Хармөрөний жанжны яамны данс” 1-1692, тал 300-304, ЭА 31 оны 7 сарын 30-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг, “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон ван гүнгий илтгэл шастир”, дэвтэр 57, Засаг хошой бэйс Анандын шастир). Онкот хэмээгдэх бүлэг хүмүүс Оросод дагаж орсон, хожим урвасан тухай орос талын тэмдэглэл мөн буй бөгөөд дэлгэрэнгүйг дээр дурдсан “Шинэ баргын найман хошуу байгуулагдсан тухай” (Зүүлт 1)-наас үзнэ үү. Мөн Хонгор дайчин гэгч болбаас, “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон ван гүнгий илтгэл шастир”, дэвтэр 58, Засаг улсын гүшээ гүн Цэвдэний шастираас үзвэл, Шолойн дөрөвдүгээр хүү bömba –ын хоёрдугаар хүү бөгөөд ЭА 27 онд нэгэн удаа Чин улсад даган орсон авч ЭА 29 онд “Галданд уулгалагдаж, дагаж эс чадсан” гэжээ. Харин энэ үед байгуулсан сумын сумын занги нарын дотор, өмнө дурдсан ЭА 29 оны 9 сарын 16-ны өдрийн Хармөрөний жанжин нараас ГМТЗЯЯ-нд явуулсан бичигт дурдагдах “Ахай дайчингийн харьяат тогонхон (togongkon), улангот (ulanggot)” овгийн толгойлогчтой нэр таарах тул “Хонгор дайчингийн харьяат”-ын дотор дээрх хоёр овгийнхон багтаж байсан нь лавтай байна. Харин Ахай дайчин ба Хонгор дайчин нь ямар холбоотойг одоогоор хэлж үл чадна.

¹⁶ “Хармөрөний жанжны яамны данс” 12-1691, т.23-28, ЭА 30 оны 6 сарын 8-ны өдрийн Хармөрөний жанжнаас ГМТЗЯЯ-нд явуулсан бичиг.

нар дээрх саналыг хэлэлцээд, тэднийг Хармөрөнд хэвээр үлдээвэл аж амьдрал нь сайжрахгүй тул Жилин, Мүгдэн зэрэг газарт нүүлгэвэл зохино хэмээн үзсэн ба эцсийн эцэст энэ саналын дагуу шийтгэхээр болж, Хиа захирах дотоод сайд Бэ Фиянгу нарыг томилж, нүүлгэх ажлыг хариуцах болов¹⁷. Чингээд мөн оны 8 сарын 6-нд Фиянгу нартай зөвлөсөн Сабсугаас Жилин, Мүгдэнд нүүлгэх хүний тоог тус бүр 1747 өрхийн 1893 эр, 5955 ам ба 1110 өрхийн 1270 эр, 5023 ам хэмээн мэдүүлж байв¹⁸. Чингээд тэднийг Жилин, Мүгдэнгийн захиргаан дахь найман (盛京, 開原, 遼陽, 熊岳, 復州, 金州, 岫巖, 鳳凰) хотод суух найман хошуунд хуваан оруулахаар болжээ¹⁹. Дашрамд дурдахад, тийнхүү нүүсэн Хонгор дайчингийн хуучин харьяат нарын дотор Хонгор дайчингийн ойр төрөл болох барга бус нэлээд тооны “халхууд” байжээ²⁰.

Нөгөө талаар, тухайн үед суманд ороогүй жижиг бүлгүүдийг тус тусын халхын уг ноёдод буцаахаар болсон авч²¹ тэдний тоо, бүрэлдэхүүн болоод буцаж нүүсэн он сар одоогоор тодорхой бус байна.

2.2 Хоёрдахь удаагийн хураалт ба сум зохиосон нь

ЭА 29-30(1690-1691) онд Хармөрөнд хураан цуглуулсан барга нарыг дээр өгүүлсэнчлэн төдий л удалгүй тэндээс нүүсэн бол эдүгээгийн хуучин баргатай гарлын хувьд шууд холбогдох нь ЭА 33(1694) онд шинээр хураасан хүмүүс болно. “Хармөрөний жанжны яамны данс”-наас үзвэл, тэднийг хураасан үйл явц дараах мэт.

Анх ЭА 33(1694) оны 2 сарын 1-нд ГМТЗЯЯ-наас бэйл агсан Цэвдэний эх Бодисуг, тайж Гүнгээсампил нар²² “Хоол улхуй(hoол улһуй) зэрэг газар” (өнөөгийн зүүн үзэмчин хошуу ба хорчин баруун гарын дунд хошууны зааг орчим) сууж буй бөгөөд зоргоор хөдлөх уг харьяат баргыг “бид захирч эс чадах тул эзэнд барья” хэмээснийг уламжлан айлтгасан аж. Тэрхүү баргууд нь ойролцоогоор “зургаа долоон зуун хүн” байсан аж. Үүнд, ГМТЗЯЯ-наас баргуудыг хүлээн авахаас өмнө тодорхой байцаах нь зүйтэй хэмээх санал оруулж, дээш айлтгасан боловч Энх-Амгалан хаан тэднийг даруй хүлээн авах талаар арга хэмжээ авахыг тушаажээ.

¹⁷ “Хармөрөний жанжны яамны данс” 12-1691, т.140-149, ЭА 30 оны илүү 7 сарын 21-ний өдрийн Хармөрөний жанжин Сабсугийн айлтгал (Зүүлт 14).

¹⁸ “Хармөрөний жанжны яамны данс” 1-1692, т.204-209, ЭА 31 оны 4 сарын 29-ний өдрийн Цэргийн явдлын яамнаас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг.

¹⁹ “Хармөрөний жанжны яамны данс” 6-1692, т.174-178, ЭА 31 оны 8 сарын 6-ны өдрийн Хармөрөний жанжнаас ГМТЗЯЯ-нд явуулсан бичиг. Гэвч тухайн үед нэгэнт байгуулсан 20 сумны дотроос 1 сумыг Жилин, Мүгдэнд нүүлгэлгүй, халхын хуучин ноёд (бэйс Ананд) буцаан өгөхөөр болсон байв.

²⁰ Жоу Шоучан. Si yi tang ri ji (周寿昌『思益堂日札』) дэвтэр 3, “Баргын байдал”, Жунхуа хэвлэлийн газар, 1987 он, pp.229-233), Тэнгэрийн тэтгэсний Дайчин улсын бүгд хууль, дэвтэр 102, Цэргийн явдлын яам, Цэргийн түшмэл талбих ариутгах хэлтэсийн зүйлийг үзвэл, Жилин, Мүгдэнд 18 сум суусан байна. Харин 1 сум хасагдсан шалтгаан тодорхой бус байна.

²¹ Тухайлбал, Хятадын Түүхийн Нэгдүгээр Архив, “Сарын эвхмэлийн данс” 26(2), т.171-175, Нингутагийн жанжин Гиданга (gidangga) нарын айлтгалд (Тэнгэрийн тэтгэсний 4 оны 10 сарын 3-нд хааны үзсэн), Жилинд суух халх сумыг үе залгамжилсан сум болгохыг гуйсан байдаг.

²² “Хармөрөний жанжны яамны данс” 12-1691, т.44-45, ЭА 30 оны 6 сарын 8-ны өдрийн Хармөрөний жанжнаас ГМТЗЯЯ-нд явуулсан бичиг.

Чингээд мөн сарын 8-ны өдөр ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжинд тушааж, тэрхүү баргуудыг “солоны газар” нүүлгэвээс зохино хэмээн дахин айлтгав. Зөвлөлийн ван, бэйл, сайд нар хэлэлцэж (мөн сарын 15-нд), хааны улаан бийрээр цохолсоны (мөн сарын 20-нд) дагуу дээрх баргуудыг солоны газар нүүлгэхийг мөн сарын 23-ны өдөр ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин Сабсуд тушааж бичиг хүргүүлэв²³. Тийнхүү жанжин Сабсу бээр Хармөрөн, Мэргэн, Чичихар хэмээх гурван хотоос цэрэг хөдөлгөж, баргуудыг хураан авч ирэхээр болов. Чингээд Сабсу нар 5 сарын 9-ны өдөр Их Хянганы нурууны өмнөд Соёлж ууланд хүрч, Гүнгээсампилтай нийлэхэд Чингийн цэрэг хөдөлсөнийг хэдийн сонссон баргууд зугтаж сарнисан тул тэд хоёр хуваагдан Сабсу өөрөө хойш Халх голын зүг, мэйрэний занги Мабудай (mabudai), бүгдийн дарга Кабай (kabai) нар баруун тийш Улхуй, Дарьгангын (dari ganggan) зүг мордов. Үүний дотор Сабсугийн биеэр удирдсан анги “Халх голын газар баргын Эсхэл (eskel) нарын 15 өрх, ... Хандгайт голд Болжохой (boljokoi) нарын 59 өрх, Мойхот хуй (moihotu hūi) голд Чимэх (cimeke), Аюуш (ayusi) нарын 250 өрх” хураав. Дээрх гурван бүлэг бүгд 324 өрхийн 1343 хүн байсан ба язгуураас хэний харьяат байсан тухайд, “бэйл агсан Цэвдэний эх Бодисугийн харьяат 84 өрхийн 105 эр, 223 эм хүүхэд. Тайж Гүнгээсампилын харьяат 240 өрхийн 318 эр, 697 эм хүүхэд” байв. Сабсу нар тэднийг авч илүү 5 сарын 11-нд Чичихарт ирж, Хуюур голын савд түр суулгав²⁴. Нөгөө мэйрэний занги Мабудай нарын удирдсан анги эхлээд Улхуй голын доод урсгалд үзэмчиний Бомбо (bombo) бэйлийн газар “Гүнгээсампил тайжийн харьяат Данжин (danjin) нарын 53 өрхийн 73 эр, 253 ам” буйг тодорхойлж, улмаар Бүргэстийн (burgesutu) газар нутаглах халхын Буджав эрдэнэ (budajab erdeni) бэйсийн хошуунд олон барга буй хэмээх мэдээ сонсоод тийш одож, Бүрүлсэрж (burul serji), Моохэо (mookeo) нарын хоёр бүлгийн “нэг зуу орчим өрх”-ийг хурааж авчээ. Гэвч бусад баргууд, өөрөөр хэлбэл Томолог зайсан (tomolok jaisang), Эет тавнан (eyetu tabunang), Дахай (dahai), Абху (abuhū), Ондуг (onduk) нарын таван бүлэг хэдийн Хэрлэн голын зүг зугтсан гэх тул Мабудай нар яаравчлан хойноос нь мөрдөж тэднийг тус голын орчмоос хураан авч, түрүүчийн хоёр бүлгийн хамтаар Их Хянганы нурууны зүг хөдлөв. Зам зуур нэг хэсэг барга оргож зугтсанд нэхэж авчрах зэргээр явсаар 6 сарын 3-ны өдөр Соёлж уулын ойр үзэмчинээс хурааж ирсэн баргуудтай нийлүүлж, мөн сарын сүүлээр Чичихарт хүрч ирэв²⁵. Эдгээр хураан авчирсан барга нар бүгд 289 өрхийн 1271 ам байв. Харьяатаар нь авч үзвэл, “бэйл агсан Цэвдэний эх Бодисугийн харьяат барга 123 өрх, 164 эр, 386 эм хүүхэд, бүгд 532 ам. Гүнгээсампил тайжийн харьяат барга 166 өрх, 223 эр, эм хүүхэд 506, бүгд 739 ам” байв²⁶. Мөн энэ хооронд Халх голын

²³ Цэвдэний тухайд, “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон ван гүнгий илтгэл шастир”, дэвтэр 56-д шастир нь буй(Засаг төрийн бэйл Цэвдэний шастир). Гүнгээсампилын тухай баттай хэлж үл чадах авч, мөн илтгэл шастирын дэвтэр 55, Засаг төрийн жүн ван Пунцагийн шастирт дурдагдах, түүний хоёрдугаар хүү Гүнгээсампил (хойно төрийн жүн ванг залгамжилсан тул уг дэвтэрт тусгай шастир байгуулсан) байж магад.

²⁴ “Хармөрөний жанжны яамны данс” 1-1694, т.177-186, ЭА 33 оны 2 сарын 23-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжин нарт явуулсан бичиг.

²⁵ “Хармөрөний жанжны яамны данс” 8-1694, т.161-173, ЭА 33 оны 5 сарын 12-ны өдрийн Хармөрөний жанжин Сабсугийн айлтгал.

²⁶ “Хармөрөний жанжны яамны данс” 5-1694, т.246-278, ЭА 33 оны 6 сарын 8-ны өдрийн мэйрэний

зүгээс шинээр 24 өрхийн 115 ам (29 эр, 86 эм хүүхэд) хураасан учир хураасан бүх баргын тоог нийлүүлбэл, 637 өрхийн 839 эр, 2729 ам болно²⁷.

Тэдгээр баргыг хэрхэх талаар 7 сарын 16-нд Сабсу дараах мэт айлтгав.

“Баргын мал бүхий, аж төрж чадах дөрвөн зуун гучин дөрвөн өрхийн таван зуун арван нэгэн эрээр дөрвөн сум зохиож, тэдний дотроос захирч чадах чадалтай хүнийг сонгон сумын занги, хүнд бошго тавиад, Хуюур голд нутаглуулан суулгая. Мал цөөтэй ядуу хоёр зуун гурван өрхийн гурван зуун хорин найман эрээр дөрвөн сум зохиож, нэг сумыг наян хоёр эр хэмээн, сум тутмаас жаран эр сонгож хуяг өмсгөе. ... Тэдний дотор захирч чадах чадалтай хүнийг сонгож сумын занги, хүнд бошго тавиад, Нэмэр (nemer) голын Бүрд (bürde) тосгоны газар өвс сайтай, газар өнтэй тул урьд суулгасан дагуур (dagūr) дөрвөн сумтай нэг газар суулгая. Тэдэнд олгох хуяг, дуулга зэргийн зэвсэг хэрэглэл болоод боол, малыг цөм урьд хуяг өмсгөсөн ядуу солон нарт өгсөн ёсоор тавьж олгоё. Энэхүү хуяг өмссөн барга нарыг тариа тарьж сурах хүртэлх хугацаанд хоёр жилийн амны тариа олгоё²⁸”

Энх-Амгалан хаан 9 сарын 6-ны өдөр үүнийг явуулсан тул дараа жилийн ЭА 34(1695) оны 2 сард Сабсу сумын занги, хүнд бошгод тавих хүнийг сонгож дуусаад Цэргийн явдлын яаманд бичиг илгээснийг 4 сарын 19-нд тус яамны хэлэлцсэнийг хаан ёсоор явуулав²⁹. Тийнхүү баргууд ерөнхийдөө хоёр хуваагдсан байна. Тухайн үед зохиосон найман сум тус бүрд сумын занги, хүнд бошго томилсон хэдий ч Бүрд орчимд тариа тарих болсон дөрвөн суманд тугийн өнгө хуваарилахын сацуу цалин, хуяг дуулга зэргийг олгосон бол Хуюур голд мал маллах болсон дөрвөн суманд дээрх зүйлийг олгосонгүй. Өөрөөр хэлбэл, баргын нэг хэсгийг албан ёсоор суурин найман хошууны хэвчээнд оруулсан бол нөгөө хэсгийг онцгойлон үзсэн байна.

Энэ мэт баргуудыг хураан авчирсан, найман сум зохиосон тухай дансанд тэдний овгийн бүрэлдэхүүнийг шууд заах тэмдэглэл эс харагдана. Харин ЭА 31(1692) онд бэйл Цэвдэнгээс, ЭА 29(1690) онд Бутхад довтлон хэрэг дэгдээсэн чивчинүд (cibcinut) овгийн нэг бүлэг хүмүүсийн тухай “Халхын Эрх цогтын харьяат баргын чивчинүд овгийн Дорж далай хиа (dorji dalai hiya) хэмээгч угтаа миний харьяат хүн. Одоо үзэмчиний Улхуйн (ulhoi) газар нутаглаж буй” хэмээн өгүүлж байсан³⁰, мөн хойно гарах ЭА 40(1701) оны 8 сарын Энх-Амгалан хаан

занги Мабудай нараас Хармөрөний жанжинд илгээсэн бичиг, мөн 11-1694, т.126-128, ЭА 33 оны 6 сарын 25-ны өдрийн мэйрэний занги Мабудай нараас Хармөрөний жанжинд илгээсэн бичиг.

²⁷ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1694, т.390-401, ЭА 33 оны 7 сарын 16-ны өдрийн Хармөрөний жанжин Сабсугийн айлтгал.

²⁸ Мөн дээрх.

²⁹ Мөн дээрх. Дурдсан агуулгыг Найралт төвийн “Дайчин улсын хууль зүйлийн бичиг”, дэвтэр 221, ГМТЗЯЯ, Зүтгэлийн тэмдэглэх ариутгах хэлтэс, Эрийн дансны зүйлд товчлон оруулсан буй.

³⁰ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1695, т.57-63, ЭА 34 оны 2 сарын 27-ны өдрийн Хармөрөний

зарлигийн дотор Хуюур голд нутаглах барга сумыг “чивчинүд нэгэн бүлэг Эрх цогт тайжийн харьяат” хэмээснээс үзвэл³¹, баргын найман сумын дотор урьд ЭА 29(1690) онд Хармөрөний жанжин нараас зугтан сарнисан “чивчинүд овог”-ийнхон багтаж байсан нь лавтай байна. Энэ нь дөрөвдүгээр зүйлд дурдахчилан, өнөөгийн хуучин баргад чивчин хэмээх овогтон олон байдагтай нийцэж байна.

Гэхдээ чивчинүд овгийг багтаагаад тухайн үед гадаад монголд зоргоор хөдөлж байсан бүхий л баргыг Хармөрөнд хураасан хэрэг бус юм. Тухайлбал, ЭА 33(1694) оны 7 сард хурааж авчирсан баргын дотор алга болсон 27 өрх хэмээн жанжин Сабсу өгүүлж байсан³², түүнчлэн ЭА 37(1698) оны 1 сард Сабсугаас ГМТЗЯЯ-нд илгээсэн бичгээс үзвэл, урьд ЭА 29(1690) онд Бүрдэд довтлон үймээн дэгдээсэн дээр нэр гарах чивчинүд овгийн Дорж далай хиа гэгчийг тухайн үед Хармөрөнд хурааж авчраагүй гэдэг нь баттай байна³³. Энэ мэт сарнисан бүлгийн ихэнхийг хожим халхын ноёд хураан авсан, мөн Цахар найман хошуунд орсон мэт. Тийм нэгэн жишээг сурвалжаас дурдвал, “Зарлигаар тогтоосон Гадаад монгол, хотон ван гүнгүүдийн илтгэл шастир”-ийн дэвтэр 56, Засаг төрийн бэйл Цэвдэний шастирт, ЭА 33(1694) онд харьяат барга нарыг Хармөрөний жанжинаас илбэн хураасан явдлыг дурдсаны хойно “Барга язгуураас хэд хэдэн нам. Чивчинүд хэмээн өргөгсөд буй амуй. Түүний тавнан тан Галданыг зайлж, зургаан зуун өрх авч засаг Арьяагийн газарт эрээр одов. Таван зуун өрхийг Хөлөнбуйрын Үрэнгийн газарт үлдээж суулгажээ. Тэд нь түших газар үгүйн учирт зарлигаар Ванжилд тушааж, түүний эхэд хэлж, хойш хураамжлан аваачуулбай.” гэж буй³⁴. Бас дээрх илтгэл шастирийн 55-р дэвтэр дэх Засаг төрийн жүн ван Пунцагийн шастирт, “[Энх-Амгалангийн] 36 он туслагч түшмэл Чанлу лугаа хамт Хардтай голд одож, бэйл Ванжилын хуучин харьяат хүн чивчинүдийн зуу илүү өрхийг хурааж, Үршин голын газарт шийтгэн суулгавай” гэж буй. Түүний дээр “Зарлигаар тогтоосон найман хошууны ойллого”-ын дэвтэр 180, Үдэзэний намтарт, “[Энх-Амгалангийн] 38 оны 1 сард зарлигаар баргын гурван мянган хүнийг дагуулан хурааж, Цахарт нутаглуулан суулгаж, сум зохиож хавсаргав” гэснээс үзэхэд, 3000 гаруй баргыг Цахар найман хошуунд оруулсан ажээ.

3. Хөлөнбуйрт нүүх хүртэл

ЭА 40(1701) он хүртэл баргын найман суманд нэлээд өөрчлөлт гарчээ. Тухайлбал, анх мөн оны нэгдүгээр сарын 18-нд Хармөрөний жанжны тушаалыг хамаарсан Шанахай (šanahai, 沙納海),

жанжин нараас Цэргийн явдлын яаманд илгээсэн бичиг, мөн 1-1695, т.225-230, ЭА 34 оны 4 сарын 30-ны өдрийн Цэргийн явдлын яамнаас Хармөрөний жанжинд явуулсан бичиг.

³¹ “Хармөрөний жанжны яамны данс” 10-1692, т.247-248, ЭА 31 оны 9 сарын 14-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжинд явуулсан бичиг.

³² Мөн дээрх.

³³ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1694, т.402-430, ЭА 33 оны 7 сарын 16-ны өдрийн Хармөрөний жанжинаас ГМТЗЯЯ-нд илгээсэн бичиг.

³⁴ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1698, т.34-39, ЭА 37 оны цагаан сарын 25-ны өдрийн Хармөрөний жанжинаас ГМТЗЯЯ-нд илгээсэн бичиг. Энд нэр зэргэцэн гарах Эрх цогтын тухай, “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон ван гүнгий илтгэл шастир”, дэвтэр 54, Сэцэн хан Өмэхэйн шастирт, “[Энх-Амгалангийн] хорин наймдугаар он, ... тайж Эрхцогт, жич баргын Бадам дарга, Соном дарга тан харьяат ардыг авч дараа дараагаар хүрч ирсэнийг зарлигаар Өмэхэйд захиргав” гэж буй.

“Сайд бид Мэргэн, Бүрдийн хоёр газар сууж буй цэргийг үзвээс, бүгд солон, дагуур, барга цэрэг бөгөөд суурин суух байдал тогтоогүй. Үүнд, хот сахигч, заланы занги, горьт түшмэлийн зэрэг залан занги дөрвөн түшмэл мэтийн хэдхэн хүн захиран тариа ногоо тарьж, харвах, намнахыг сургаж, нарийвчлан захирч хууль ёсоор шийтгэх явдлыг ер чадахгүй. Тиймээс сайд бид санахад, Бүрдийн тарианы газрыг үзвээс Мэргэнтэй нэгэн адил, Мэргэний газар мод ихтэйн дээр Хармөрөнд ойр, машид чухал тул Бүрдийн хот сахигч, хоёр горьт түшмэл, дагуур баргын сумын занги, хүнд бошго, дөрвөн зуун ерэн цэргийг бүгд, Бүрд Мэргэнээс холгүй нэгэн зуун далан газрын зайтай, нүүхэд бэрхгүйд энэ жил Мэргэнд нүүлгэж, бүгд нэг мянга нэг зуун дөчин цэргийг цөм Мэргэний газар суулгаж, тариа тариулья. ... Эдүгээ сайд бид байцааваас, Энх-Амгалангийн гучин найман оны байцаасан дансанд, Бүрдэд сууж буй баргын дөрвөн сумын эр хоёр зуун дөчин дөрөв, мал маллах дөрвөн сумын эр дөрвөн зуун гучин гурав, энэ хоёр газрын эрийг нийлүүлбэл зургаан зуун далан долоон эр. Мал маллах дөрвөн зуун гучин гурван эрийн дотор мал нь барагдаж, амь улжих малгүй, машид ядарсан хүн олны дээр энэ хэвээр мал маллуулах аваас тэдгээр барга уг зан сурталыг үл өөрчлөх тул хэзээ ч манжтай нэгэн адил болохгүй. Тиймээс сайд бид бодвоос, Мэргэнд нүүлгэн суулгая хэмээх дөрвөн сумын хоёр зуун дөчин баргын хуяг нарт тэдний язгуурын дагалт эр (holbohon) дээр мал маллах дөрвөн зуун гучин гурван эрийн дотроос нэмж хоёр зуун дөчин дагалт болгож, Мэргэнд нүүлгэн тариа тариулья. Хуягийн орон гарахыг үзэж дагалт эрийн дотроос чийрэг бөгөөд харвах намнаж чадахыг үзэж хуяг өмсгөө. Мөн үлдсэн нэг зуун ерэн долоон эрийг Чичихарт буй хуучин цэргийн суманд эрийн олон цөөнийг харгалзан, зохисыг үзэж оруулья. ... Энэ мэт болговоос барга нар цөм амьдрах замыг олж, хуучин цэрэгт тариа тарих эр бардаагаар хүрэлцэх тул мөн тус бүхий. Улмаар жил удахад барга нар хууль ёсоор манжтай нэгэн адил болж, олон хэрэгт хэрэглэхэд хоцрох үгүй болох аваас, хааны тариа, цалинг хэрэглэн баргыг тэжээж, манжийн нэгэн адил болгох хэмээсэн Дээрхийн санаанд сая нийцмүй.”³⁵

³⁵ Тэрхүү “засаг Арьяагийн газар одсон” 600 гаруй өрхийн тухай Хааны ордон музейн сурвалж эрхлэн хэвлүүлэх хорооноос эмхэтгэн хэвлүүлсэн “Ордоны данс: Энх-Амгалангийн үеийн айлтгал” (国立故宫博物院故宮文獻編輯委員會編輯『宮中檔康熙朝奏摺』) боть 8, 1977 он, pp.227-230 дахь Энх-Амгалан хааны хунтайжид илгээсэн захидалд (ЭА 35 оны 5 сарын 18-нд Бээжинд хүлээн авсан) мөн дурдсан байдаг.

хэмээн айлтгав. Өөрөөр хэлбэл, Бүрдэд суух дагуурын 4 сум, баргын 4 сум бүгдийг Мэргэнд шилжүүлэн суулгаж, Хуюур голд нутаглах баргын 4 сумын нэг хэсгийг Мэргэнд нүүлгэх 4 суманд нийлүүлэх, нэг хэсгийг Чичихарын манж суманд оруулъя хэмээжээ. Ийнхүү дахин суманд оруулах санал гаргах болсон нөхцөл тодорхой бус авч тухайн үед Шанахай өмнөх тушаалын жанжин Сабсу цэргийн тоог худал мэдүүлсэн хэргээр ял олж, түүний оронд жанжны тушаалыг хамаараад удаагүй³⁶ байсантай холбогдох юун магад.

Дээрх саналыг Цэргийн явдлын яам зэрэг газар хэлэлцсэний дараа 2 сарын 29-нд Энх-Амгалан хаан зөвшөөрснөөр хэрэгжүүлэх болсон авч³⁷ хэрэг дээрээ тийм ч хялбар байсангүй. Юуны өмнө, дээр дурдсанчлан хааны зөвшөөрөл Хармөрөнд хожуу ирсэн учир Шанахай 4 сарын 11-нд Цэргийн явдлын яаманд бичиг илгээж, Бүрдийн түшмэл цэргүүдийг тэр даруй Мэргэнд нүүлгэх аваас “тарианы улирлыг алдах” тул намар хүртэл хойшлуулъя хэмээхэд ёсоор болгов³⁸. Гэтэл 8 сард малжих дөрвөн сумны бүтцэд мөн өөрчлөлт гарав. Тухайн үед Соёлж уулын орчим биеэр ирсэн Энх-Амгалан хаанд бараалхахаар Шанахай Хармөрөний олон түшмэл цэргийг дагуулан одсон³⁹ тухайд малжих сумны занги Эргэл (ergel), Данжин (danjin) нар дараах бичгийг өргөжээ.

“Богд эзэн биднийг Энх-Амгалангийн гучин нэгэн онд биднийг аж төрж чадахгүй гачигдсаныг тэжээн тэтгэж, аму шагнаан өгч тэжээгээд хоёр зуун дөчин эрийг Бүрдийн цэрэгт хуяг өмсгөн цалин олгон тэжээж буй. Мөн нэг зуун дөчин эрийг Чичихар хотын цэрэгт хуяг өмсгөн, цалин олгон тэжээж буй. Үлдсэн аж төрж чадах сул хоёр зуун дөчин эрийг Богд эзэнд дагаснаас хойш есөн жилийн хугацаанд элдэв албанд оруулалгүй өршөөн тэжээв. Хишиг хүртсэнээр бидний аж төрөл урьдахтай харьцуулашгүй сайн болов. Одоо гуйх нь, богд эзэн тусгайлан өршөөлт хишгийг хариулъя хэмээвч эс чадах өчүүхэн боол Эргэл, Данжин ... нар богд эзний хишгийг

³⁶ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1701, т.3-16, ЭА 40 оны цагаан сарын 18-ны өдрийн Хармөрөний жанжины тушаалыг хамаарсан Шанахай нарын айлтгал. Энэ айлтгал дахь хань хамсаа хэмээх утгатай манж хэлний holbohon хэмээх үгийг дагалт эр хэмээн орчуулав. (Зохиогч үүнийг 附丁 хэмээн японоор орчуулсаныг дагалт эр хэмээн монголчлов. Орч).

³⁷ “Шэнзү хааны магад хууль”, дэвтэр 203, ЭА 40 оны 2 сарын шарагчин хонь өдрийн зурваст, “Зөвлөлийн сайд нар хэлэлцээд айлтгасан нь. “Хармөрөний жанжин Сабсу цэргийн тоог худал мэдүүлж, сангийн тариаг илүү олгосны тул тушаалаас байлгавал зохино” хэмээв. Хэлэлцсэн ёсоор болго.” мөн сарын хөхөгчин үхэр өдрийн зурваст, “Нингутагийн жанжин Шанахайг Хармөрөний жанжин болго” гэж буй.

³⁸ “Хармөрөний жанжны яамны данс” 1-1701, т.64-72, ЭА 40 оны 3 сарын 6-ны өдрийн Цэргийн явдлын яамнаас Хармөрөний жанжинд явуулсан бичиг.

³⁹ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1701, т.113-117, ЭА 40 оны 4 сарын 11-ний өдрийн Хармөрөний жанжинаас Цэргийн явдлын яаманд илгээсэн бичиг, мөн 1-1701, т.104-107, ЭА 40 оны 5 сарын 8-ны өдрийн Цэргийн явдлын яамнаас Хармөрөний жанжинд явуулсан бичиг. Гэвч малжих сумын эрийн нэг хэсгийг Чичихар дахь найман хошуунд оруулах явдал нь хойно эш татах мөн оны 8 сарын сумын занги Эргэл нарын айлтгалаас (Зүүлт 41) харахад, тэр хүртэл хэрэгжээгүй бололтой.

хариулж эс чадах тул гагц бидний гуйх нь, богд эзэнд булга барьж буй солон, дагуурын бутхагийн бүлэгт нэмж оруулан, амь хайрлалгүй чадлын хэрээр хүчин зүтгэж, булганы алба бариулахыг гуйж сөгдөн өргөв⁴⁰”

Тийнхүү малжих сумын эрийн дотроос Чичихарын найман хошуунд орсоныг эс тооцон⁴¹ үлдсэнийг Бүрдээс Мэргэнд нүүлгэх дөрвөн сумтай нийлүүлэлгүй Бутхад харьяалуулахыг хүссэн аж. 8 сарын 14-нд Энх-Амгалан хаан энэ хэргийн талаар Шанахай нарт хэлэлцэхийг тушаасан авч тэд малжих сумыг Мэргэнд нүүлгэх дөрвөн сумтай нийлүүлэхээр хэдийн айлтгаад хааны зөвшөөрөл буусан учир өөрчлөх шаардлагагүй хэмээн үзэв. Гэтэл хаан харин ч “тэднээр булга бариулбал болох бус уу. Булга ч илүү олно. Ямар нэг үл болох зүйл байна уу” хэмээн дахин хэлэлцэхийг тушаав⁴². Баргуудын дээрх мэт хүсэлт гаргасан, үүнийг Шанахай эцсээ хүртэл дарах гэж оролдсоны цаана ямар нэг учир буй мэт санагдах авч одоогоор үүнийг тодорхой болгох хэмжээний сурвалж эс олдоно. Тэгээд хааны саналыг хүлээн авсан Шанахай аргагүй дараах арга хэмжээ авахаар болов.

“Сумын занги байсан Эргэл, Данжин нар, аж төрж чадах мал бүхий зуу гаруй эрээр хоёр сум зохиож, дутдун (dukдун), ял (yal) хоёр ав(aba)-тай нийлүүлэв. Мөн үлдсэн ная гаруй мал үгүй ядуу ардыг солон, дагуур тавин гурван сумны дотор амь зуулга сайтайд нь нийлүүлж, булга бариулна⁴³”

Эдгээр сурвалж дахь барга сумны дахин зохион байгуулалтын явцыг зургаар илэрхийлбэл, Зураг1 болно. Тийнхүү ЭА 33(1694) онд Хармөрөнд хураан цуглуулсан барга нарыг Мэргэн, Чичихар, Бутха хэмээх гурван газарт хуваан суух болжээ.

Түүний дараа ч Хөлөнбуйрт нүүх хүртэлх хугацаанд баргын суух газар, зохион байгуулалт үе үе өөрчлөгдөж байв. Бүрдээс Мэргэнд нүүсэн дөрвөн сум ЭА 45(1706) онд цааш Чичихарт нүүсэн нь тэдгээр сумны занги нар баргын сум эрийн тоо цөөрч, дагуур нар хуягийн дотор 65 ор эзлэх болж, энэ хэвээр байх ахул барга сумын хувьд оршин тогтнож чадахгүйд Чичихарт буй нэгэн угсааныхтай нийлүүлж өгөхийг хүссэнтэй холбоотой⁴⁴. Тэрхүү дөрвөн сум түүнээс хойш Чичихарт удаан хугацаагаар сууж байсныг сурвалжаас магадалж болно⁴⁵. Дараагаар ЭА 56(1717) онд анх солон, дагуур суманд орсон баргууд (67 эр) “булга

⁴⁰ “Шэнзү хааны магад хууль”, дэвтэр 205, ЭА 40 оны 8 сарын шар морь өдрийн зурваст,”Дээрх, ...бэлийн газар буув. ... Хармөрөний жанжин Шанахай, Солонь бүгдийн дарга гиоро Ату нар тэдний доорх түшмэл цэргийг дагуулан, бараалхахаар ирэв.” гэж буй.

⁴¹ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1701, т.253-259, ЭА 40 оны 8 сарын 15-ны өдрийн Хармөрөний жанжин Шанахай нарын айлтгал.

⁴² Өмнө дурдсан Шанахай нарын цагаан сарын айлтгалд (Зүүлт 36), ЭА 38 онд шалган байцаасан тоог үндэслэж, Чичихарын манж суманд оруулбал зохих эрийн тоог 197 хэмээсэн авч, тус данснаас үзвэл 140 эр орсон мэт.

⁴³ Зүүлт 41.

⁴⁴ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1701, т.325-328, ЭА 40 оны 11 сарын 11-ний өдрийн Хармөрөний жанжинаас ГМТЗЯЯ-нд илгээсэн бичиг. Тус дансанд, Бутхад оруулсан эрийн тоог урьд Мэргэнд нүүлгэх суманд харьяалуулахаар тогтсон 240 эрээс цөөхөн, бүгд нийлээд 180 гаруй эр хэмээснийг анхаарвал зохино.

⁴⁵ “Хармөрөний жанжны яамны данс” 2-1706, т.77-82, ЭА 45 оны 7 сарын 6-ны өдрийн Хармөрөний жанжин Бодин(bodin) нарын айлтгал.


авлахыг сурсан, аж төрөх хогшил бүхий болсон” хэмээн баргын хоёр суманд буцаан оруулахыг гуйсан авч, үүнийг зөвшөөрсөнгүй⁴⁶.

Мөн дээр дурдсан Энх-Амгалангийн 30-40-д оны данснаас баргын эрийн тоо (хүн ам) байнга цөөрөх хандлагатай байсныг мэдэж болно. Үүнд, байгалийн жамаар цөөрсөн үү, бусад угсаатаны дунд орж ууссан уу гэдгийг шууд тодорхойлон хэлэхэд бэрх. Алин боловч Хармөрөний газар нь баргууд нь барга хүний хувиар оршиж үлдэхэд тийм ч таатай орчин бус байсан бололтой.

НТ 9(1731) оноос дараагийн жил хүртэлх хугацаанд Найралт төв хааны удирдлага дор Бутха болон Халхаас цэрэг эр татаж, Хөлөнбуйрт найман хошуу байгуулах төлөвлөгөө хэрэгжсэн үйл явцыг хэдийн авч үзсэн тул энд үл өгүүлнэ⁴⁷.

Нэгдүгээр бүлэгт дурдсанчлан, энэ үед Хөлөнбуйрт нүүсэн баргын 275 эр (хүүхэд, хөгшдийг үл тооцон) нь ЭА 40(1702) онд Бутхад хавсаргасан хүмүүсийн үр сад болох нь мэдээжийн хэрэг билээ

Зураг 1.



Харин тухайн үед Бутхад хавсаргасан бүх барга Хөлөнбуйрт нүүсэн эсэх нь тодорхойгүй авч, хожмын бутха сумны өөрчлөлттэй холбогдох элдэв данс сурвалжид барга сумны тухай ер эс гарах тул багаар бодоход Бутхад байсан барга сум бүхлээрээ нүүсэн гэж үзэж болох мэт. Юу боловч, тэдгээр нүүгсэдийн үр хойч нь өнөөгийн Хуучин барга хошууны баргууд мөн болно. НТ 12(1734) онд урьд Энх-Амгалангийн 30-д оны үймээнээр халхын ноёд хураан аваачсан баргуудыг

⁴⁶ Жишээлбэл, Сичиний “Хармөрөний гадаад тэмдэглэл 西清『黒龍江外記』(1810 онд зохиогдсон), дэвтэр 3-т, Чичихарт суух 40 сумны зангийн дотор “барга дөрвөн түшмэл” багтаж байсныг тэмдэглэсэн. Бас Бө.Шабу “Хармөрөний монгол судлал 波・少布『黒龍江蒙古研究』”(Хармөрөн мужийн Үндэстэн судлалын хүрээлэн, 1990 он) т.39-д, 1958 онд Чичихарт 407 барга тоологдсон хэмээжээ.

⁴⁷ “Хармөрөний жанжны яамны данс” 1-1717, тал 81-89, ЭА 56 оны 9 сарын 2-ны өдрийн ГМТЗЯЯ-наас Хармөрөний жанжинд явуулсан бичиг.

Хөлөнбуйрт нүүлгэсэн тул тэднээс ялгахын тулд Бутхагаас нүүж очсон баргыг хуучин барга(манжаар *fe barhū*) хэмээн нэрлэх болжээ.

Энд хуучин болон шинэ баргын холбоог дахин цэгцэлж үзье. Эхлээд овгийн бүрэлдэхүүнийг авч үзвэл, тэднийг нүүх үеийн овгийн бүрэлдэхүүнийг тодорхой дурдсан сурвалж эс олдох тул Дундад Иргэн улсаас хойш үед хамаарах хэдэн сурвалжаас хуучин, шинэ баргын овгийг харьцуулбал Хүснэгт 1 болно.

Дараагийн бүлэгт дурдахчилан, Хөлөнбуйрт нүүсний дараах Хуучин болон Шинэ баргын хооронд томоохон хүн амын харилцан шилжилт болоогүй хэмээн санах тул дээрх хүснэгт дэх овгийн бүрэлдэхүүнийг нүүсэн тухайн үеийнхээс онц өөрчлөгдөөгүй гэж үзэж болно. Хүснэгтээс харахад, Хуучин баргын овогт Шинэ баргынхтай таарах нь цөөхөн байна. Үүн дээр баргууд Чин улсад дагаж орохоос өмнө их төлөв овгоор бүлэглэн явж байсныг харгалзвал, Шинэ барга нь угтаа Хуучин баргатай нэгэн бүлэгт хамаарч байсан хүмүүс байх магадлал өндөр мэт. Тухайлбал, НТ 11(1733) онд Чичихарт суух барга сумны харьяат агсан Хөлөнбуйрын бүгдийн дарга Дабаха(*dabaha*, *cibcinud* овогтой)-гаас, шинээр нүүн ирсэн шинэ баргын дотор сарниж салсан өөрийн авга(*eshen*) буй хэмээн мэдүүлж байсан явдал нь дээрх таамаглалыг батлах нэг боловч жишээ болно⁴⁸.

Хүснэгт 1.

Хуучин барга			Шинэ барга	
Хармөрөний ойллогын ноорог (黑龍江志稿), дэвтэр 11	Тэних, чирэгт явуулсан судалгааны статистик эмхэтгэл	Монгол хэлээр	Хармөрөний ойллогын ноорог (黑龍江志稿), дэвтэр 11	Шинэ барга баруун хошууны барга овгийн үе залгамжийн бичиг
齊普欽努特	shibuchin, chipuchin	cabacin?	齊普欽努特	
鄂里木蘇	orumuso	orimsu	—	orimsu
富察	—	—	—	—
呼爾拉特	orurato/hororato/ horara/ horurato	qorlad	—	qorlad
烏里雅特	—	oliyad	—	oliyad
李佳	—	—	—	—
胡佳	—	—	—	—
	oraegon/eruegen/ uregun/ oreigon/ haranoto	eriyegen	—	—
	gaboshuudo/ gapushuto	qaranud γabcid	—	—
	sharunuto/sharunoto	siranud	—	—
			哈勒斌 哈勒林	—
			葉克忠	qalgin?
			永舍布	yekejüng
			奎車里克	yüngsiebü
			康錦	küicelig
			戴卜羅	qanggin
			戴佳	


* “Тэних, чирэг аймгийн бодит байдлын судалгааны статистик эмхтгэл”: Энэ өгүүлэлийн дөрөвдүгээр бүлэг болон Зүүлт 54-ийг үзмү.

⁴⁸ “Сарын эвхмэл данс” 12(2), т.185-186, Жагдан (*jakdan*) нарын айлтгал.

- * “Монгол хэлээрх тэмдэглэл”: Bōkūnūdtei yuncuγ nayirayulba, Mongγul obuγ. Öbür mongγul un soyul un keblel ün qoriy-a, 1993 (官其格編『蒙古族姓氏』内蒙古文化出版社)дахь дүйцэх овгийн нэрийн тэмдэглэл.
- * ”Шинэ барга баруун хошууны барга овгийн үе залгамжийн бичиг” буюу Sin-e barγu barayun qosiyun-u barγu obuγ un üy-e jalyamji yin bicig. Цбыг mongγul un soyul un keblel ün qoriy-a, 1990: 1985 оны хээрийн судалгааг үндэслэн Шинэ барга баруун хошууны 45 овгийг дурдсан буй авч уг хүснэгтэд зөвхөн Хуучин барга болоод “Хармөрөний ойллогын ноорог”-т тэмдэглэсэнтэй давхардах овгийг оруулав.

Одоо хуучин, шинэ баргыг захирч байсан ноёдын харилцаа холбоог авч үзье. Дээр өгүүлсэнчлэн, хуучин барга нь угтаа Сэцэн хан аймгийн бэйл Цэвдэн(cebden), тайж Гүнгээсampil (gungge sampil) нарын харьяат билээ. Тэдэн дээр шинэ барга болон ЭА 29(1690) онд Хармөрөний жанжны хураан авч, хожим Жилин, Мүгдэнд нүүн суусан баргуудын хуучин эзнийг (мэдэгдэж буй) нэмж, угийн зурагт тэмдэглэж үзвэл Зураг 2 болно.

Зураг 2: Баргуудыг харьяалж байсан Сэцэн хан аймгийн ноёд



- * Угийн бичгийг “Зарлигаар тогтоосон Гадаад Монгол, Хотон ван гүнгийн илтгэл шастир”-т үндэслэн үйлдсэн ба энэ өгүүлэлтэй төдий л холбоогүй хүнийг оруулаагүй болно.
- * Тодоор Сэцэн ханыг тэмдэглэв
- * Долгионтой доогуур зураасаар, ЭА 29(1690) онд Хармөрөнд хураагдаж, дараагаар Жилин, Мүгдэнд нүүсэн баргын харьяат ноёдыг тэмдэглэв.
- * Шулуун доогуур зураасаар, ЭА 33(1704) онд Хармөрөнд хураагдсан барга(нэг хэсэг нь

хожмын хуучин барга болсон) нарын харьяат ноёдыг тэмдэглэв.

* Тасархай доогуур зураасаар, НТ 12(1734) он хүртэл шинэ баргуудын байсан хошууны засаг ноёдыг тэмдэглэв.

Дээрх зурагт шинэ баргын тухайд НТ 12(1734) онд Хөлөнбуйрт нүүхээс өмнөхөн үеийн байдлыг илэрхийлсэн ба хоёрдугаар бүлэгт дурдсанчлан Чин улсад дагаж орохоос өмнө баргын аль бүлэг хэн хэмээх ноёнд харьяалагдаж байсан нь тодорхой тул Галдангийн довтолгооны улмаас сарниж тархсан баргуудыг халхын ноёд дахин хураан аваачихад олонх нь хуучин эзэндээ захирагдсан хэмээн ойлгож болох буй за. Тиймээс хуучин болон шинэ баргын овгийн тухай мэдээлэлийн он цагийн зөрүүг төдий л тоох хэрэггүй мэт. Шинэ баргын дотор Мүгдэн, Жилинд нүүсэн барга болоод хуучин баргын хуучин эзэн уг хүн, эсвээс түүний ойр төрлийн ноёдын харьяатаас татаж гаргасан хүмүүс нэлээд буйг Зураг 2-оос мэдэж болно. Ийнхүү харьцуулж үзэхэд, Хуучин болон Шинэ барга нь угтаа нэг буюу ойр төрлийн бүлэг байсан тул хоёр этгээдийн хооронд угаас тодорхой ялгаа байсан хэрэг бус бөгөөд тэд Хармөрөн ба Халхад хуваан захирагдсан, хожим дахин Хөлөнбуйрт ойр хөрш суух болсон явдал нь тохиолдлын хэрэг гэдэг нь тодорхой харагдаж байна.

4. Түүнээс хойшх Хуучин барга буюу дүгнэлт

Хөлөнбуйрт нүүсний дараа ч хуучин баргын хошууны тогтолцоонд өөрчлөлт гарч байв. Энэ тухай дэлгэрэнгүй эс өгүүлэн, зөвхөн гол өөрчлөлтийг дурдая. Анх Тэнгэрийн тэтгэсний 7(1742) онд Солон, Дагуур, Хуучин баргаас бүрдэх найман хошууны (Солон найман хошуу гэгддэг) 50 сумнаас, дагуураар голлон бүрдэх 26 сумыг Бутхад буцаахад, хуучин баргын 297 эр үлдэхийг хүсчээ⁴⁹. Манж Чин улсын сүүл хүртэл Солон найман хошууны 24 сумны зохион байгуулалт хэвээр хадгалагдагдсан бөгөөд түүний дотор хуучин барга нар зүүн гарын Хөвөөт цагаан хошуунд 3 сум (гэхдээ нэгдүгээр сум нь солон барга нийлсэн), Шулуун хөх хошуунд 3 сум бүрдүүлж байв⁵⁰. Дундад Иргэн улсын 8(1919) онд л Хөвөөт цагаан хошууны нэг, хоёрдугаар сум болоод Шулуун хөх хошууны 3 сумны баргууд Солоны зүүн гараас тусгаарлаж, бие даасан 2 хошуу (хөвөөт цагаан, шулуун хөх) 12 сум болжээ⁵¹. Түүний дараа “Манжго” улсын үед хөвөөт цагаан, шулуун хөх 2 хошууны тогтолцоог халж, нийлүүлэн хуучин барга 1 хошуу болгосон⁵² нь өнөөгийн хуучин барга хошууны үндэс болсон билээ.

Гэхдээ дээрх мэт өөрчлөлтийн үеэр хүн амын томоохон нүүдэл болоогүй тул баргын нийгэмд суурь өөрчлөлт гараагүй болов уу хэмээн санана. Үүнийг дам

⁴⁹ “Сарын эвхмэл данс” 32(2), т.333-361, Хармөрөний жанжин Бодь (bodi) нарын айлтгал (Тэнгэрийн тэтгэсний 7 оны 4 сарын 6-нд хааны үзсэн).

⁵⁰ Өвөрмонголын Өөртөө Засах Орны эрхлэн хэвлүүлэх хороо, “Дагуур үндэстэний нийгэм, түүхийн судалгаа 内蒙古自治区編輯組『達斡爾族社会歴史調査』” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо, 1985, т.24.

⁵¹ Мөн дээрх болон “Хармөрөний ойллогын ноорог”, дэвтэр 26, Цэргийн зэвсгийн тэмдэглэл, Цэргийн хэмжээ.

⁵² Манжийн байдлыг танилцуулах газар эмхэтгэв, “Манжго улсын эдүгээ буй үндэстэн 滿洲事情案内所編『滿洲国の現住民族』”, Манжийн байдлыг танилцуулах газрын тайлан, (46) Зассан хэвлэл, 1937 он, pp.51-52.

батлах сонирхолтой баримт буйг дурдвал, “Хуучин барга хошууны тэних, чирэг аймгийн бодит байдлын судалгааны статистик эмхтгэл” болно. Энэ нь “Манжго” улсын үед явуулсан хуучин барга хошууны тэних, чирэг аймгийн 29 өрхийн асуулга судалгаа⁵³ бөгөөд үүнд нэр гарах 29 өрхийн овог, хуучин харьяалагдаж байсан хошуу, сумын нэрээр хоёр этгээдийн харьцааг илэрхийлбэл, Хүснэгт 2 болно.

Хүснэгтээс харахад, 29 өрхийн дотор төвд ламаас(ван овогт) бусад нь шипчин (чивчин), орээгон (эрүэгүн, үрэгүн, орэйгон) хоёр овог нь хөвөөт шар хошуунд, харнуд, уларад (холарад, хулар, холурад), оримс, габшууд (гавшуд), шарнуд (шарнод) овог нь шулуун хөх хошуунд харьяалагдаж байсан, түүнчлэн нэг сумны тухайд ч нэг овог нэг суманд төвлөрөх хандлагатай байсан нь тодорхой байна. Энэ нь Чин улсаас овгийг үндэс болгож хошуу, сум зохиосон, Дундад Иргэн улсын үед ч тэрхүү үндсэн зохион байгуулалт уламжлагдан ирсэнийг дам харуулж байна⁵⁴.

Хүснэгт 2.

Хошууны нэр		Хөвөөт цагаан						Шулуун хөх					
Овог	сум	1	2	3	4	5	6	1	2	3	4	5	6
Шипшин				3	2	4							
орээгон						3	1						
харнуд									6				
уларад										4			
оримс									1				
габшууд												2	
шарнуд												1	1
ван(төвд лам)										1			

Дээр авч үзсэнчлэн, урьд Халхад харьяалагдаж, барга хэмээн нэрлэгдэж байсан хүмүүсийн дотор хожмын хуучин баргатай шууд холбогдох бүлэг анхнаасаа байсан хэрэг бус юм. Галдан Халхад довтлох үеэр дүрвэж Хармөрөнд орсон хүмүүс хийгээд Халхад үлдсэн хүмүүсийн хооронд тодорхой зааг ялгаа байгаагүй болно. Мөн Хармөрөнд орсон дараа ч Чин улсын төрийн бодлого

⁵³ “Хуучин барга хошууны тэних, чирэг аймгийн бодит байдлын судалгааны статистик эмхтгэл” Хянганы хойт мужийн Шинэ барга баруун гарын хошуу, Солон хошуу, Хуучин барга хошууны бодит байдлын судалгааны статистик эмхтгэл, Улсын явдлын газар, Хянганы товчоо, Хянганы мужийн бодит байдлын судалгааны материал, Статистик эмхтгэл III. Энэхүү судалгаа явуулсан болоод тайлан хэвлэгдсэн оны тухай Ёшида Жүничи “Хянганы дөрвөн мужийн бодит байдлын судалгааны тухай: Хаалттай монгол нутагт явуулсан судалгаа 吉田順一「興安四省実態調査について—非開放蒙地の調査を中心に—」” Васэда их сургуулийн бакалаврын дараах сургалт, Хүмүүнлэгийн ухааны сургуулийн сэтгүүл, 43-4, 1988 оны 2 сар, pp.57-71-т дурдсанаас үзвэл, тайлан хэвлэгдсэн он тодорхой бус авч Тэних,чирэг аймагт судалгаа явуулсан нь 1940 оны 7 сар болно.

⁵⁴ Энэ нь угтаа өөр хошуу, суманд харьяалагдаж байсан хүмүүс тухайн үед нэг айл бүлэг болон сууж байсан, өөрөөр хэлбэл бодит амьдрал дээр Чингийн үеийн хошуу, сумны зохион байгуулалт алдагдсаныг харуулна. Гэхдээ энэ нь Хөлөнбуйрт нүүснээс хойшх хошууны тогтолцооны өөрчлөлт нь Хуучин баргын нийгэмд тийм ч их өөрчлөлтөнд хүргээгүй хэмээн таамаглалтай зөрчилдөж буй хэрэг бус, өөр түвшингийн асуудал болно.

шийдвэр буюу баргуудын хүслээр үе үе зохион байгуулалт өөрчлөгдөж, улмаар нэг хэсэг нь Хөлөнбуйрт нүүсэн нь өнөөгийн Хуучин барга болно. Өөрөөр хэлбэл, хуучин барга болбаас Манжийн захиргаанд орохоос өмнөх нийт баргын дотроос санамсаргүй бас зориудаар таслан хуваагдсан нэг хэсэг болно.

Өнөөгийн хуучин барга хошуу болон шинэ барга зүүн хошууны хооронд газар зүйн хувьд саад бэрхшээл тухайлан үгүй. Хайлаар, Манжуурыг холбосон замаар явбал, нүдний өмнө мянган газрын тэртээ хүртэлх тал нутаг цэлийж, нэг мэдэхэд л хошууны хилийг даваад өнгөрнө. Хуучин болон шинэ барга нь угтаа нэг гаралтай буюу ойр төрөл бүлгүүд байсан, түүгээр үл барам Хөлөнбуйрт нүүснээс хойшх 250 гаруй жилийн турш тийнхүү зэрэгцэн нутаглаж ирсэн атал хуучин баргыг соёлын хувьд шинэ баргаас ялгагдах онцлог бүхий тул тодорхой хэмжээгээр угсаатны бүлэг хэмээн үзэх ахул, үүний шалтгааныг нэгдүгээрт, хуучин баргын өвөг дээдэс Их Хянганы нуруунаас зүүн тийш Нон мөрөнний сав газраар нутагласан 40 жилтэй холбож үзвэл зохино. Тэр хугацаанд шинэ баргууд гагц халхын нөлөөн дор байсан бол хуучин баргууд солон, дагуур, манж зэрэг олон угсаатантай харьцаатай байсан явдал нь тэдний хоорондох ялгаа буй болоход нөлөөлсөн болов уу. Ялангуяа, шинэ баргын хэл аялгуу нь хуучин баргатай харьцуулахад илт халхтай ойр⁵⁵ болоод хуучин баргад бурханы шашин шинэ баргаас сул дэлгэрсэний шалтгааныг дээрхээр тайлбарлах боломжтой. Хоёрдугаарт буюу нэгдүгээр шалтгааны нөгөө тал буюу хуучин баргууд Нон мөрөнөөр нутагласан нь 40 жил төдийгөөр эргэн Хөлөнбуйрын тал нутагт нүүснээр тэднийг тариачин болох, монгол бус угсаатанд уусах явдлаас зайлуулсан гэдэг утгаар чухал ач холбогдолтой. Гуравдугаарт, тухайлан Хөлөнбуйрт нүүсэн тухайд Чингийн захиргааны тогтолцооны нөлөөг бодолцвоос зохино. Солон найман хошууны зүүн гарт харьяалагдах хуучин барга болон тусгай шинэ баргын зүүн баруун гарыг бүрэлдүүлэх шинэ баргууд газар зүйн хувьд зэргэцэн оршиж байсан авч Чингийн төрийн зарлиг тушаал уламжлах, дайны үед цэрэг татах, түшмэл томилох зэрэг нь тус тусдаа явагдаж байв⁵⁶. Энэ мэт засаг захиргааны нэгдмэл бус байдал нь хоёр этгээдийн нийгмийн харилцаа холбоонд саад болж, хуучин болон шинэ баргын ялгаа удаан хугацаанд хадгалагдах чухал нөхцөл болохын хувьд тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан буй за. Одоогийн хуучин баргууд угсаатны бүлгийн хувьд оршин тогтнож буй хэв маяг нь дээрх мэт түүхэн учир шалтгааны улмаас хэвшин тогтжээ.

Энэ удаа дээрх мэт дүгнэлтэд хүрсэн авч энэ нь хязгаарлагдмал сурвалжид тулгуурлан гаргасан таамаглал төдий зүйл болно. Хуучин барга хэмээх бүлгийг бүрэлдэхэд хүргэсэн хүн амын нүүдлийн үйл явцын тухайд тодорхой мэдлэгтэй болсон авч ХҮП зуунаас өнөөг хүртэлх хуучин баргын нийгмийн өөрчлөлт, соёл угсаатны хувиралтын тухайд сурвалжид тулгуурлан дэлгэрэнгүй авч үзэх түвшинд одоогоор хүрээгүй байна. Тухай олдох ахул хойшид сурвалж баримт цуглуулж, улам нарийвчлан судлах болно.

⁵⁵ Хаттори Широо “Хөлөнбуйрын монгол хэл” (Зүүлт 4).

⁵⁶ Энэ тухай Янагисава Акира “Бутха, Хөлөнбуйр дахь “найман хошуу”-ны шинж чанар: Тухайлан Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамтайх харьцааны тухай 柳澤明「ブトハとフルンブイルにおける「八旗」の性格—特に理藩院との関係について」Чингийн үеийн Хятадын асуудлууд, Эмхэтгэсэн Ишибаши Хидэо, Ямакава хэвлэлийн газар, 1995, pp.349-364-ийг үзмү.

Abstract: *Geographically, one can not find serious difficulty in passing nowadays from Old Barga banner to Eastern New Barga banner. He would see a great steppe stretching a thousand kilometer passing the boundary line before he knows where he is if he travels along the road which connected Hailar and Manchuria. Ethnically, Old and New Bargas have a common origin; that is, they are different groups of close relation. They have lived adjacent to each other without any serious problem for over 250 years after their resettlement in Hulun Buir. However, some scholars consider Old Barga as a separate ethnic group distinct culturally from New Barga. In my view, there are three main reasons. The first reason should be related to the forty years settlement of the Old Barga in the Non River basin after the migration of their ancestors to the south from Greater Khinggan Range. While the New Barga was during their settlement under the Khalkha supervision, the Old Barga had an active relationship with various ethnic groups such as Solons, Dagurs and Manchus. Probably it made significant contribution to their distinction. Especially basing on this study, it is possible to explain the reasons why the New Barga dialect comparing with the Old Barga one is more similar to the Kalkha dialect and why the Old Barga conversion to Buddhism was stronger than the New Barga. Secondly, the Old Barga remigrated to the plain of Hulun Buir after forty years settlement along the Non River. It was the most significant event for them to avoid adopting an agriculture-based sedentary way of life and acculturating into other non-Mongol ethnic groups. Thirdly, as for their deportation to Hulun Buir, it should be considered the particularity of Qing administrative system. Two Bargas, the Old Barga, who were attributed to the Left Flank of Solon Eight Banners, and the New Barga consisting of its Right and Left Wings, coexisted geographically, but their services to the Qing rule such as posting of imperial orders, army enrolment for war, appointment of officials were administratively separate.*

Such kind of administrative distinction impeded their mutual relationship providing main contribution to the lasting separateness between two Bargas. It was a historical reason for present ethnical difference between the Old and New Bargas.

Уг өгүүлэл Япон улсын Васэдэ их сургуулийн Ази-Номхон далай судлалын хүрээлэнгээс (Institute of Asia-Pacific Studies) эрхлэн гаргасан Social Sciences Review сэтгүүлийн Vol. 44(2), 129, 1999-01, 345-369-р талд япон хэлээр хэвлэгдсэнийг О.Оюунжаргал монголчилж, тус сэтгүүлийн шаардлагын дагуу товч утга, түлхүүр үг, англи товчийг нэмж үйлдэв.